

**“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН –ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ**

2024 оны 11 сарын 27

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт
Зорилт 2.2. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.		
1	2.2.1. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдэл, хөгжлийн бэрхшээл үүсгэж байгаа шалтгааныг тодорхойлж, хувь хүний онцлогт тохируулан урьдчилан сэргийлэх, оношлох тогтолцоог санхүүжилтийн аргатай нь уялдуулан бүрдүүлж, үйл ажиллагааг хэвшүүлнэ.	“Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээ” төв байгуулах төслийн гүйцэтгэх ажлын жагсаалтыг 2023 оны 05/02 өдрийн А/163 тоот тушаалаар баталж, MRI, ангиографийн зэрэг тоног төхөөрөмжүүдээр ханган, хүний нөөцийг сурган, оношилгооны чадамжийг сайжруулан, гүйцэтгэлийн санхүүжилтийн орлого нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх ажлууд хийж, MRI, СТ суурилуулж байна.
2	2.2.3. Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, тэдний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх	<p>-Зонхилон тохиолдох хавдруудаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг сэдвээр 20 төрлийн цуврал постер зөвлөмж НЭМҮТ-тэй хамтран боловсруулж цахимаар түгээсэн.</p> <p>-Умайн хүзүүний хорт хавдар, хавдрын эрт илрүүлэг, хавдрыг даван туулах сэдвээр 3 подкаст НЭМҮТ-тэй хамтран хийж, олон нийтэд түгээсэн.</p> <p>-Хавдрын эрсдэлт хүчин зүйлс ба хавдрын эрт илрүүлэг сэдвээр 2 төрлийн видео шторк хийж олон нийтийн цахим сүлжээ болон МҮОНТ, UBS, Малчин, С1, ТВ5, Ийгл ТВ-ээр давтамжтайгаар түгээсэн.</p> <p>-Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний талаарх ярилцлага, мэдээллийг МҮОНРТ, UBS, С1, TV9, TV5, ТВ8, ETV, Eagle, Монгол HD, TV 25, Монголын үндэсний олон нийтийн Радио МҮОНР), Монголын радио болон Өдрийн мэдээ, Зууны мэдээ зэрэг 14 хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан хүн амд хүргэсэн.</p> <p>- МҮОНР-той хамтран элэг, ходоод, умайн хүзүү, хөх, уушигны хорт хавдрын сэдвээр 5-н цуврал зөвлөгөө өгөх нэвтрүүлгийг мэргэжлийн эмч нараа оролцуулан хийсэн.</p> <p>- Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, ХПХВ-ийн эсрэг дархлаажуулалтын сэдвээр ТВ хэлэлцүүлгийг МҮОНТ-тэй хамтран НЭМҮТ, ХӨСҮТ, Хавдрын үндэсний зөвлөл ТББ, даван туулагчдын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.</p>

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт
		<ul style="list-style-type: none"> - Хавдрын дэлхийн өдрийг тэмдэглэх хүрээнд “Цагаан үзэг” холбоотой хамтран сургалт зохион байгуулж, 30 сэтгүүлч хамрагдсан. - ХСҮТ, НЭМҮТ, ХӨСҮТ, Хавдрын үндэсний зөвлөл ТББ-ын удирдлагууд танилцуулга мэдээлэл хийсэн. - Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн сэдвээр Тайваны гэр бүлийн сантай хамтран эмзэг бүлгийн айл өрхийн 68 хүнд 1 удаа сургалт зохион байгуулсан. <p>Сувилахуйн албанаас үйлчлүүлэгчид болон олон нийтэд зориулсан “Бид таны туслагч” сэдэвт сувилагчийн нэг өдөр өдөрлөгийг 7 тасаг баталсан төлөвлөгөөний дагуу зохион явуулж, 577 хүнийг хамруулан сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан.</p>
3	2.2.5. Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагддаг болгож хэвшүүлнэ.	<p>2020 онд Эрүүл мэндийн хуулийн 35.1 заалтад нэмэлт өөрчлөлт оруулан дараах хорт хавдрын эрт илрүүлэх үзлэг оношлогоог зохион байгуулахыг заасан байна.</p> <ul style="list-style-type: none"> - Элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт дөч болон түүнээс дээш насны, гепатитийн В, С вирус тээгч, элэгний архаг үрэвсэл, хатууралтай иргэнийг элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд жилд 1-2 удаа; - Ходоод, улаан хоолойн хорт хавдрын эрт илрүүлэгт дөч, түүнээс дээш насны иргэнийг, дурангийн шинжилгээнд жилд 1 удаа; - Умайн хүзүү, хөхний эрт илрүүлэгт гучаас жаран насны эмэгтэйг эсийн шинжилгээнд 3 жилд 1 удаа; - 35,45 насанд нь эмэгтэйг ХПВ өндөр эрсдэлт хэв шинж илрүүлэх шинжилгээг 1 удаа; - Уушигны хавдрын эрт илрүүлэгт тавь болон түүнээс дээш насны иргэнийг цээжний зураг авах шинжилгээнд жилд 1 удаа; - Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын эрт илрүүлэгт тавь, түүнээс дээш насны иргэнийг өтгөнд далд цус илрүүлэх шинжилгээнд хоёр жилд 1 удаа тус тус хийхээр тусгасан байна. <p>Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/379 тоот тушаалын дагуу улс орон даяар хэрэгжсэн “Хүн амын эрүүл мэнд, эрсдэлд суурилсан эрт илрүүлэг үзлэг”-ийн хорт хавдар оношлогдсон тохиолдолд дүн шинжилгээ хийсэн. Тайлангийн үр дүнгээр:</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдээс хавдрын сэжигтэй 5797 хүний мэдээллийг шалгаж хорт хавдар оноштой 371(С-304, D-66, Z-1) тохиолдлыг илрүүлсэн. Нийт оношлогдсон хорт хавдрын байрлалаар хуваан харвал ходоод-154, элэг-110, улаан

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт
		<p>хоолойн -49, бөөр-13, хөх-8, уушиг-8, умайн хүзүү-6, бусад байрлалын-23 хорт хавдар тус тус оношлогдсон байна.</p> <ol style="list-style-type: none"> 2. Хорт хавдар онош баталгаажсан 371 хүнээс 2024 оны 03 дугаар сарын 22-ны байдлаар 82 хүн нас баржээ. Ундраагаас тодруулах 3. Илрүүлгээр хорт хавдар гэж бүртгэгдсэн 226 хүн өмнөх онуудад аймаг дүүргийн хавдрын хяналтад орсон бүртгэлтэй, үүнээс 25 хүн нас барсан байна. 4. Анх оношлогдсон хорт хавдрын өвчлөлийг 100 000 хүн амд харьцуулан тооцоход эрэгтэй хүйсэнд ходоод, элэг, улаан хоолой, уушигны хорт хавдрууд, эмэгтэй хүйсэнд ходоод, элэг, улаан хоолой, бөөр, хөхний хорт хавдрууд байна. 5. Анх оношлогдсон хорт хавдрын оношлогдох үеийн үе шатыг тодорхойлоход 37.7% нь эрт үедээ(0-2 үе шат), 62.3% нь хожуу үедээ(3-4 үе шат) оношлогджээ. 6. Хорт хавдрын өвчлөлийн түвшин 65-аас дээш насны бүлэгт хамгийн өндөр 100 000 хүн амд 91.35 тохиолдол ногдож байна. 7. Хорт хавдар оношлогдсон нас хамгийн залуу 1 нас, хамгийн ахмад нас нь 88 байна. 8. Анх оношлогдсон хорт хавдрын 84.6%-д нь хавдрын өвөрмөц мэс засал+хими, хими+туяа, мэс засал+хими+туяа эмчилгээнд хамрагдсан байна. 9. Анх оношлогдсон хорт хавдрын 203 (54.7%) нь аймгуудад, 168(45.3%) нь Улаанбаатар хотынх байна. 10. Хорт хавдрын өвчлөлийн түвшин бүсүүдээс Улаанбаатар хот, дүүргүүдээс Сүхбаатар дүүрэг, аймгуудаас Баян-Өлгий аймагт өвчлөл өндөр ногдож байна.
5	2.2.6. Төрийн болон аж ахуйн нэгж байгууллага бүр ажилтан, албан хаагчдаа эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, жил бүр урьдчилан сэргийлэх цогц үзлэг, шинжилгээнд хамруулдаг соёлыг хэвшүүлнэ.	<p>Хавдар судлалын үндэсний төвийн ажилтнуудыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж, эрүүл мэндийн түвшинг тогтоон, өвчлөлийг эрт оношилж, өвчлөл хүндрэлээс урьдчилан сэргийлэх, ажилтнуудын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилго бүхий “Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг 2021-2023 онд батлан хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>2024 онд уг хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулан “ХСҮТ-ийн Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөр” (2024-2026 он), төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>(Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөрийн дагуу 2024 оны эхний хагас жилийн хугацаанд хийсэн тайланг хавсаргав.)</p> <ul style="list-style-type: none"> • 2024 оны 3-р сард нийт ажилтнуудад лабораторийн шинжилгээ ба үзлэг, оношилгоо шинжилгээ гэсэн хоёр үе шаттайгаар урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн. Нийт 524 ажилтан үүнээс шинэ ажилтан 54, үндсэн 470 ажилтан үзлэгт хамрагдахаас үзлэгт оношилгоонд 451 ажилтан (96%), шинжилгээнд 469 (99%) хамрагдсан (эм-349, эр-102). • Төвийн ажилчдад эмэгтэй 13, эрэгтэй 9 төрлийн оношилгоо шинжилгээ хийсэн.

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт
6	2.2.7. Урьдчилан сэргийлэх анагаах ухааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, төгсөлтийн өмнөх болон дараах онолын, дадлага сургалтын чанарыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгож хөгжүүлнэ.	<p>Төгсөлтийн дараах сургалт: “Хими эмчилгээ судлал” төрөлжсөн мэргэшлийн 6 сарын сургалтад 16 эмч, мэргэжилтнийг хамруулснаас аймаг, дүүргийн 6 эмчийг сургаж, чадавхижуулсан. Үүнд: Баянхонгор, Сэлэнгэ, Ховд, Дархан-Уул, Өмнөговь аймаг болон Баянгол дүүрэг</p> <p>2024 онд тус төвийн төгсөлтийн дараах сургалтанд: Хавдар судлал үндсэн мэргэшлээр 9 эмч, төрөлжсөн мэргэшлийн “Хавдрын хими эмчилгээ судлал” сургалтанд 7 эмч, толгой хүзүүний мэс засал сургалтанд 7 эмч, эмэгтэйчүүдийн хавдар судлал сургалтанд 6 эмч, хавдрын туяа эмчилгээ судлалын сургалтанд 2 эмч тус тус амжилттай хамрагдаж төгссөн ба эдгээр эмч мэргэжилтнүүдийн сургалтын хөтөлбөрт хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт суртчилгааны талаар тусгасан. Сургалтанд төрийн сангийн зардлаар Дундговь АНЭ, Дорноговь АНЭ, ХУДНЭ, БГДНЭ, УНТЭ-ийн эмч нар хамруулан дадлагажуулж чадавхжуулсан.</p> <p>2024 онд шинээр“ Хавдрын хими эмчилгээний найруулга зүй”-н мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж онол, дадлага сургалтын олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, сургалтыг 2024 оны намрын элсэлтээр эхлүүлэн аймаг болон дүүргийн эм зүйч, эм найруулагч нарыг сургалтанд хамруулж эхлээд байна. Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн эмч нарын баг Сүхбаатар, Увс, Хөвсгөл аймагт ажиллаж, 20 гаруй мэс заслыг орон нутгийн эмч нартай хамтран хийж, 2-3 төрлийн мэс заслыг дээрх 3 аймагт нутагшуулсан.</p> <p>-21 аймаг, 9 дүүргийн хавдар бүртгэгч нарыг хамруулсан цахим сургалтыг зохион байгуулж, хорт хавдрын өвчлөл, нас баралт, хяналтын сарын мэдээ, мэдээний сангийн үйл ажиллагаа сэдвийн хүрээнд хийгдсэн.</p> <p>- Баянзүрх дүүргийн 26-р хорооны Өрхийн ЭМТ-ийн нийт 41 эмч нарт “Хорт хавдаргүй хот удиртгал сургалт”-ыг зохион байгуулж 1 багц цаг олгосон.</p>
9	2.2.12. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжинэ.	<p>“Эс Эф Си Эс” ХХК нь “ISO 9001:2015” магадлах аудит орсон. Аудитийн дүгнэлтээр 2 жижиг үл тохирол, сайжруулах 3 саналтайгаар “Стандартын шаардлага үргэжлүүлэн хангаж байна” гэж дүгнэсэн.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/554 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт дагуу Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагыг магадлан шинжлэх шалгуурын дагуу бэлтгэл ажил хийж ажилласан. Магадлан итгэмжлэлийн шалгалтанд орж 3 жилийн хугацаатайгаар “Магадлан итгэмжлэл”-ийг сунгуулж Магадлан итгэмжлэлийн гэрчилгээг гардан авсан. Эрүүл мэндийн тусламжийг амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.</p>

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт
10	<p>2.2.13. Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.</p>	<p>“Сайн туршлагын сан- Шинэ технологи”-гийн хөтөлөлтийг сайжруулж эмнэлгийн хэмжээнд сурталчилан таниулж үйл ажиллагаанд бүрэн нутагшуулсан байна. 2024 оны байдлаар 7 тасгийн 16 шинэ технологийг нэвтрүүлэн ажиллаж байна.</p> <p>1.Ерөнхий мэс заслын тасаг</p> <ol style="list-style-type: none"> 1. Шээдэг сүвээр дамжуулан хийгдэх давсаг болон түрүү булчирхайн мэс засал 2. Ходоодны дурангийн мэс засал <p>2. Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг</p> <ol style="list-style-type: none"> 1. Үтрээний хүрцээр нэг оролттой хэвлийн дурангаар өндгөвчний хавдар авах мэс засал. 2. Том хэмжээтэй миомын хоргүй хавдартай умайг хэвлийн дурангаар “Morcellator” багаж ашиглан жижиглэж авах мэс засал. <p>3. Эмнэлзүйн эмгэг судлалын лабораторийн тасаг</p> <ol style="list-style-type: none"> 1. Cobas-Pure, Биохими, иммунологийн шинжилгээний аппарат бүрэн автомат аппарат, 2. BH-550 Клиник лаборатори цусны ерөнхий шинжилгээний аппарат 3. QAGEN Молекул биологийн лабораторт эдийн автомат аппарат 4. BIROAD Молекул биологийн лабораторт PCR-н автомат аппарат <p>4. Хөхний төв</p> <ul style="list-style-type: none"> • Харуул тунгалгийн булчирхай болон нөхөн сэргээх мэс заслын үеийн далбангийн цусан хангамжийг ICG тодосгогч бодисоор шалгах • Стереотактик эдийн шинжилгээний хэрэглээ • Хөхний эмгэгийн цогц заавар, тусламж удирдамж • Олон улсын нарийн мэргэжлийн эмч мэргэжилтэнгүүдтэй хамтарсан зөвлөгөөний шийдвэрийн хариуг загварт оруулах <p>5. Туяа эмчилгээний тасаг</p> <ol style="list-style-type: none"> 1. Туяа эмчилгээний TrueBeam шугаман хурдасгуур аппаратад суурилсан <p>6.Хими эмчилгээний тасаг</p> <ol style="list-style-type: none"> 1. Хавдрын дархлаа эмчилгээ

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт
		7. Сэргээн засах эмчилгээний тасаг 1. Shockwave apparatus: Булчин суллах, өвдөлт намдаах, үрэвсэл дарах 2. Vest series airway clearance System HFCWO: Уушгины багтаамж нэмэгдүүлэх
11	2.2.14. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.	<ul style="list-style-type: none"> - Хавдрын эрсдэлт хүчин зүйл, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн талаар олон нийтэд мэдээлэн сурталчлах дараах ажлууд хэрэгжлээ. Үүнд: - Зонхилон тохиолдох хорт хавдруудаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн сэдвээр 20-н төрлийн цуврал постер зөвлөмжийг НЭМҮТ-тэй хамтран боловсруулж цахим хэлбэрээр түгээсэн. - Зонхилон тохиолдох хавдрын урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, хавдрыг даван туулах болон сэтгэл зүйн сэдвээр нийт 16 удаагийн лайв зөвлөгөөг ХСҮТ дангаараа болон НЭМҮТ-тэй хамтран хийсэн. - Хавдрын эрсдэлт хүчин зүйлс ба хавдрын эрт илрүүлэг сэдвээр 2 төрлийн видео шторк хийж олон нийтийн цахим сүлжээ болон МҮОНТ, UBS, Малчин, С1, ТВ5, Ийгл ТВ-ээр давтамжтайгаар түгээсэн. - “Эмчийн нэг өдөр” 3-н цуврал баримтат киног толгой хүзүүний нөхөн сэргээх мэс засал, улаан хоолойн хавдрын дурангийн мэс засал, элэгний хавдрын үеийн элэг шилжүүлэн суулгах мэс засал зэрэг зөвхөн ХСҮТ-д хийгддэг мэс засал эмчилгээний сэдвээр хийн МҮОНТ, UBS TV, ТВ-5, ТВ-9, Малчин ТВ-ээр олон нийтэд цацаж хавдрын мэс заслын эмчийн үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний онцлогийг сурталчилсан. - МҮОНРТ, UBS, С1, TV9, TV5, ТВ-8, ETV, Eagle, Монгол HD, 25-TV, Малчин ТВ, Тэнгэр ТВ, NTV, Монголын радио болон Өнөөдөр, Өдрийн мэдээ, Зууны мэдээ сонин, сайтууд зэрэг 20 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний талаарх ярилцлага, мэдээллийг хүн амд хүргэсэн. - ОН-д зориулсан сургалтыг Тайваны хүүхэд гэр бүлийн хөгжлийг сан-68 хүн, 84-р сургуулийн 7-р ангийн 60сурагч, УБ театрын 100 ажилтан, хэвлэл мэдээллийн сэтгүүлч 20хүн, өрхийн эмч, ЕБС-ийн эмч 150 хүн, Угсаатны соёл, хэл хуурын холбооны 200 гаруй хүн зэрэг 600 гаруй хүнд 7 удаагийн сургалт хийсэн. - НЭМ-ийг дэмжих жил, Дэлхийн тамхигүй өдөр, Хавдрын эсрэг Дэлхийн өдөр, Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдөр, Хөхний хавдрын сард зориулсан 5-н удаагийн кампанит ажлыг төвийн тасаг албадыг оролцуулан зохион байгуулж, 1500 гаруй хүнийг хамрууллаа.

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт
		<ul style="list-style-type: none"> - МҮОНР-той хамтран элэг, ходоод, умайн хүзүү, хөх, уушигны хорт хавдрын сэдвээр 5-н цуврал зөвлөгөө өгөх нэвтрүүлгийг мэргэжлийн эмч нараа оролцуулан хийсэн. - Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, ХПХВ-ийн эсрэг дархлаажуулалтын сэдвээр ТВ хэлэлцүүлгийг МҮОНТ-тэй хамтран НЭМҮТ, ХӨСҮТ, Хавдрын үндэсний зөвлөл ТББ, даван туулагчдын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. - Хорт хавдрын хяналтын хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд НЭМҮТ-тэй хамтран хорт хавдраас урьдчилан сэргийлэх ажлын хэсэгт ажиллаж байна. Энэ хүрээнд зонхилон тохиолдох 7-н хавдрын анхдагч урьдчилан сэргийлэлтийн сэдвийн агуулга, чиглэлийг боловсруулах, холбогдох нарийн мэргэжлийн эмч нарыг оролцуулах ажлууд хийгдэж байна. - ЭМЯ-ны Ажлын хэсэгт НЭМҮТ, ХӨСҮТ, НҮБ-ын Хүүхдийн Сан зэрэг байгуулагууд оролцсон. - ХПВ-ийн эсрэг дархлаажуулалтын сургалт сурталчилгааны ажлын хэсэгт ажиллаж олон нийтэд хандсан мэдээлэл сурталчилгаа, ЕБС-ийн захирал, нийгмийн ажилтан, сургуулийн эмч болон өрхийн эмч нарт сургалтууд хийх ажилд хамтран ажиллаж байна.
13	2.2.18. Иргэд эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн улмаас санхүүгийн эрсдэлд орохоос сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, мэдээллийн үнэлгээг Эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын магадлан итгэмлэлийн шалгуур үзүүлэлтүүдээр хийж, магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангахад чиглэсэн сайжруулалтыг тогтмол хийж, ажиллаж байна. - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж “Нэг Цонхны үйлчилгээ”- г үзүүлж хэл яриа сонсголын бэрхшээлтэй өөрөө өөртөө үйлчлэх чадвар сул иргэдэд нэг дороос бүх үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрдүүлэн /цаг олгох, товлох, шинжилгээ өгөх, эм олгох/ зэрэг үйлчилгээг үзүүлдэг. - Бүртгэлийн ажилчдад ашиглах дохионы хэлний цагаан толгойн гарын авлага байршуулсан. - Машины зогсоол дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэглэгээ бүхий 6 тусгай зогсоол бүрдүүлсэн. - Ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан суултуур бүрдүүлсэн. - Төв хаалганы орох гарах хэсэг шатгүй, таяг тэргэнцэртэй хүн орох гарахад ээлтэй нөхцөл бүрдүүлсэн.

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт
		<ul style="list-style-type: none"> - Гадаа явган хүн зам нь хараагүй иргэдийн хөтөчтэй. - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх тэргэнцэр 11 байгаа ба 2024 онд 4 тэргэнцэр шинээр авсан.
15	2.2.20. Төрийн өмчийн эмнэлгийн санхүүжилтийн болон удирдлагын бие даасан хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл үе шаттайгаар хэрэгжиж байгаа бөгөөд 2022 онд нэг худалдан авалтын тогтолцоонд бүрэн шилжсэн. Эрүүл мэндийн даатгалын сангаас 100% санхүүжиж байна.
17	2.2.22. Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг бүрэн нэвтрүүлнэ.	2024 оны ЭМДҮЗ-ийн 06 тогтоолоор хавдрын үеийн тусламж үйлчилгээнд хорт хавдрын үеийн дархлаа эмчилгээ, шугаман хурдасгуурын аргаар хийх өндөр технологийн туяа шарлага (IMRT/VMAT) эмчилгээ, өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээнд эмгэг судлалын шинжилгээ, сэргээн засах эмчилгээний төрлүүд нэмэгдсэн бөгөөд амбулаториор үзүүлэх өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээнүүдийг амбулаторийн цогц тусламж үйлчилгээнд оруулж ОБХ-ийн жагсаалтаас хасагдсан. 2024 оны 10 сарын байдлаар дархлаа эмчилгээнд 93 тохиолдолд 818,6 сая төгрөгний тусламж үйлчилгээг үзүүлж, шугаман хурдасгуурын аргаар хийх өндөр технологийн туяа шарлага (IMRT/VMAT) эмчилгээг 3092 удаа хийж 2,4 тэрбум төгрөгийг тус тус ЭМДС-аас нэхэмжилсэн байна.
18	2.2.23. Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж экспортод гарах гарцыг дэмжин “брэнд” болгоно.	Хавдрын сэргээн засах тусламж үйлчилгээнд уламжлалт эмчилгээний арга болох зүү засал эмчилгээг орчин үеийн анагаах ухааны эмчилгээний аргуудтай хослуулан эмчилж байна. 2024 оны байдлаар толгой хүзүүний байрлалтай хавдрын мэс заслын дараа үүссэн хэл ярианы бэрхшээл, нүүрний саа, саажилт, залгих бэрхшээл болон ходоод, бүдүүн гэдэсний мэс заслын дараа үүссэн гэдэсний парезтай нийт 103 эмчлүүлэгчид зүү засал эмчилгээ хийсэн байна.
20	2.2.25. Эмчилгээ, оношилгоо, сургалтад алсын зайн анагаах ухааныг (телемедицин) өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх түвшинд ашиглаж хэвшинэ. Алслагдсан сумын эрүүл мэндийн төвөөс холбогдож үйлчлүүлэгч зөвлөгөө авах боломжийг бүрдүүлнэ.	<p>Тус төвийн Ерөнхий захирлын 2024 оны А/28 тоот тушаалаар “ХСҮТ-ийн зайн сургалт зөвлөгөө өгөх” ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хуваарийг батлан зайн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж байна. 2024 оны 03 сарын 02-ны өдрөөс эхлэн нийт 4 удаагийн зайн сургалтыг хөнгөвчлөх эмчилгээний чиглэлээр хийж Сүхбаатар, Архангай, Дорноговь, Завхан аймгийн нэгдсэн эмнэлгийн нийт 105 эмч мэргэжилтнийг хамруулсан. Мөн хими эмчилгээний дараах хяналтаар телемедицин ашиглан Сүхбаатар, Архангай аймгийн хавдартай нийт 5 өвчтөнүүдэд ХСҮТ-ийн хими эмчилгээний эмч нар зөвлөгөө өгсөн.</p> <p>ЭМХТ-эй хамтарч дараах 6 сэдвээр видео контент бэлтгэж, цахим сургалт явуулж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1 Хавдартай өвчтөний гэрийн сувилахуй 2 Хөнгөвчлөх эмчилгээний үеийн арьсны сувилахуй 3 Хавдрын хөнгөвчлөх тусламж үйлчилгээний ерөнхий ойлголт, зарчим

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт
		<p>4 Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний бодлогын бичиг баримт, баримтлах зарчим</p> <p>5 Өвдөлтийг удирдах</p> <p>6 Хавдрын бүртгэл судлал</p> <p>Хөхний төвд маммографийн аппаратыг хиймэл оюун ухаанд суурилсан програмтай холбож, хөхний хорт хавдрын оношилгоонд хиймэл оюун ухаанд суурилсан технологийг нэвтрүүлсэн байна. Умайн хүзүүний хорт хавдрын эрт оношилгоонд хиймэл оюун ухаанд суурилсан үтрээний дуран нэвтрүүлээ.</p>
22	2.2.27. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	<p>ХСҮТ-ийн барилга байгууламж, дэд бүтцийн засварын ажлын 2024 оны төлөвлөгөөнд 14 ажил төлөвлөн 70-100% гүйцэтгэлтэй засвар үйлчилгээний ажлууд хийгдэж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Гал тогооны тааз - В1 давхрын бялдаржуулах өрөөний засвар - Галын цэгүүдийн иж бүрдэл, тохижилт - Өргөтгөлийн барилгын ЦТП-д ялтсан бойлер солих - Мэс заслын тасгийн агааржуулалтын засвар - Байгууллагын доторх хаягжилтын ажил - Төв байрны ачааны лифт засвар - Туяа эмчилгээний блокын их засвар - Лабораторын тасгийн их засвар - Төвийн ариун цэврийн өрөөнүүдийн их засвар <p>Төлөвлөгөөт хугацаа нь дуусаагүй үргэлжиж буй ажлууд:</p> <ul style="list-style-type: none"> - Өргөтгөлийн барилгын цахилгааны хаалттай дэд өртөөнд автомат сэлгэн залгуур суулгах - Төвийн дулаан хангамжийн салбарласан Ф-150-ын 60 метр төвийн бойлор хүртэлх шугмыг шинэчлэх - Тамхины цэгийг шинэчлэх
23	2.2.28. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.	<ul style="list-style-type: none"> - ХСҮТ нь Roche ХХК, ЭМЯ-тай хамтран төсөл хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн. Үүнд: Дархлаа эмчилгээг Монгол улсад нэвтрүүлэн ажиллаж байна. - Монгол улсад эмчлэгдэх боломжгүй өвчнүүдийн жагсаалтанд байсан. Стереотактик туяа эмчилгээг нэвтрүүлсэн. - Австри улсын засгийн газрын хөнгөлттэй зээлээр шугаман хурдасгуур өргөтгөх ажил хийгдсэн мөн өндөр нарийвчлалтай шугаман хурдасгуур шинээр авсан. - Робот мэс заслын сургалтын симуляторыг суурилуулан ашиглаж эхлэв. Роботын удирдлага бүхий мэс заслыг нэвтрүүлэх анхан шатны

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт
		<p>сургалтыг явуулж, төхөөрөмжийн зарим дагалдлах эд анги, хэсгүүдийн сольсноор хавдрын мэс заслын хагалгаанд ашиглах боломж бүрдэнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Хагалгааны 3D/4K дүрслэл бүхий дуранг ашиглалтад оруулж, 3 хэмжээсээр харах, илүү өндөр нарийвчлал, чанартай дүрслэл бүхий дэлгэц, дурангийн хагалгааг гүйцэтгэх боломжтой болсон.
24	<p>2.2.29. Хүн амын хэрэгцээ, тусламж үйлчилгээний зохион байгуулалт төлөвлөлттэй уялдуулан хүний нөөцийг бэлтгэж, орон нутгийн хэрэгцээг хангаж, эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгон бодит цалингийн хэмжээг улсын дунджаас дээш байлгана.</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хөдөлмөрийн тухай хуулийн 107, 108, 109 дүгээр зүйлийг үндэслэн Монгол улсын Засгийн газрын “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2024 оны 128 дугаар тогтоолын 6, 10 дугаар хавсралтыг үндэслэн зарим албан тушаалын ажилтан тус бүрийн үндсэн цалинг тодорхой хувиар нэмэгдүүлэн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн. Тус төв нь 2023 оны 04-р сарын 03-ны өдрөөс эхлэн их эмч, сувилагч, эм зүйч, физикч инженер гэсэн 4-н албан тушаалын ажилтнуудыг эмнэл зүйн цогц чадамжид суурилсан цалингаар цалинжуулж эхэлсэн. Үүнээс гадна ур чадвар мэргэжлийн зэрэг, дэвийг харгалзан дараах нэмэгдлийг олгон ажиллаж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Хоол унааны нэмэгдэл–110000₮, (ЭМС-ны 2018 оны 548 дугаар сайдын тушаалыг үндэслэн) - Хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл: Хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажилтанд үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдлийг сар бүр тогтмол - Цолны нэмэгдэл – Үндсэн цалингийн 10 хувь, - Ур чадварын нэмэгдэл – 10-25 хүртэлх хувь - Хариуцлагын нэмэгдэл – Албан тушаалын хариуцлагын дагуу, - Илүү цагийн хөлс – Илүү цагаар ажилласан хөлсийг 1,5 дахин, - Шөнийн цаг ажилласны нэмэгдэл – 1 цаг тутамд 1000 төгрөгөөр тооцох - Хавсран ажилласны хөлс – Хавсран ажилласан албан тушаалтанд - үндсэн цалингийн 40 хүртэлх хувь, 2. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолын дагуу Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2023 оны 1 дүгээр сарын 2-ноос эхлэн ажилласан жил бүрээр тооцон 1-25 хувиар өгч эхэлсэн ба одоо 478 ажилтан уг нэмэгдлийг авч байна. 3. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын баримтлан “Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл урамшуулал олгох” журам, Хавдар судлалын үндэсний төвийн дүрмийг үндэслэн эмч, ажилтны ажлыг сар бүр дүгнэж, улирал тутамд үндсэн цалингийн 20 хүртэлх хувийн нэмэгдэл мөнгөн урамшууллыг олгож байна. 2024 оны 1 дүгээр улиралд 446, 2 дугаар улиралд 419, 3 дугаар улиралд 416 ажилтанд тус тус урамшуулал олгосон байна.

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт
25	2.2.34. Эрүүл зөв дадал хэвшил эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах багш, мэргэжилтэн, сургагч багш нарыг бэлтгэж мэдлэг, чадвар болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах, сургах арга зүйг тогтмол сайжруулах боломжийг бүрдүүлнэ.	<p>Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2, 144.4 дүгээр зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тус төвийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 19 ажилтанд хууль тогтоомжийн дагуу хөнгөлөлт (ХХОАТ-ны 10 хувийг НД болон ЭМ-ийн даатгалын тодорхой хувиар чөлөөлсөн ээлжийн амралтад нэмж олгох г.м)-ийг эдлүүлэн ажилласан.</p> <p>Ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 19.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, мэдээллийн үнэлгээг ЭМТҮЧАБ-ын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүдээр хийж, магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангахад чиглэсэн сайжруулалтыг тогтмол хийж, ажиллаж байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж “ Нэг Цонхны үйлчилгээ” -г үзүүлж хэл яриа сонсголын бэрхшээлтэй өөрөө өөртөө үйлчлэх чадвар сул иргэдэд нэг дороос бүх үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрдүүлэн /цаг олгох, товлох, шинжилгээ өгөх, эм олгох/ зэрэг үйлчилгээг үзүүлдэг.</p> <p>Бүртгэлийн ажилчдад ашиглах дохионы хэлний цагаан толгойн гарын авлага байршуулсан.</p> <p>Машины зогсоол дээр 6 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэглэгээ бүхий тусгай зогсоол бүрдүүлсэн.</p> <p>Ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан суултуур бүрдүүлсэн.</p> <p>Төв хаалганы орох гарах хэсэг шатгүй, таяг тэргэнцэртэй хүн орох гарахад ээлтэй нөхцөл бүрдүүлсэн.</p> <p>Гадаа явган хүн зам нь хараагүй иргэдийн хөтөчтэй.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх тэргэнцэр 11 байгаа ба 2024 онд 4 тэргэнцэр шинээр авсан.</p>
27	2.2.36. Иргэд орчин үеийн эмчилгээ, оношилгооны өндөр өртөгтэй, нарийн төвөгтэй, оношилгоо, эмчилгээ хийлгэх тохиолдолд зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас олгох үйл ажиллагааг өргөжүүлнэ.	<p>2024 оны ЭМДҮЗ-ийн 06 тогтоолоор хавдрын үеийн тусламж үйлчилгээнд хорт хавдрын үеийн дархлаа эмчилгээ, шугаман хурдасгуурын аргаар хийх өндөр технологийн туяа шарлага (IMRT/VMAT) эмчилгээ, өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээнд эмгэг судлалын шинжилгээ, сэргээн засах эмчилгээний төрлүүд нэмэгдэж орсон болон амбулаториор үзүүлэх өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээнүүдийг амбулаторийн цогц тусламж үйлчилгээнд оруулж ОБХ-ийн жагсаалтаас хасагдсан. 2024 оны 10 сарын байдлаар дархлаа эмчилгээнд 93 тохиолдолд 818,6 сая төгрөгний тусламж үйлчилгээг үзүүлж, шугаман хурдасгуурын аргаар хийх өндөр технологийн туяа шарлага (IMRT/VMAT) эмчилгээг 3092 удаа хийж 2,4 тэрбум төгрөгийг тус тус ЭМДС-аас нэхэмжилсэн байна.</p>
28	2.2.37. Иргэн, даатгуулагч эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээ болох сэргээн засах, сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ авах зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ.	<p>Хөнгөвчлөх, сэргээн засах тусламж үйлчилгээний зардлыг ЭМДС-гаас 100% хариуцан санхүүжүүлж байна. 2024 оны эхний 10 сарын байдлаар сэргээн засах амбулаторийн тусламж үйлчилгээнд 1974 иргэнд 44,1 сая төгрөг, өдрийн эмчилгээнд 542 иргэнд 151,4 сая төгрөг, хөнгөвчлөх эмчилгээний 934 хүнд 841,2 сая төгрөгний тусламж үйлчилгээг тус тус үзүүлсэн байна. 2024 оны ЭМДҮЗ-ийн 06 дугаар тогтоолд орсон өөрчлөлтөөр сэргээн засах өдрийн эмчилгээний төрлүүд нэмэгдэж 4 төрлийн сэргээн засах эмчилгээг хийж байна.</p>

№	Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа	Хэрэгжилт
29	2.2.38. Анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээг хиймэл оюун ухаанд тулгуурлан хөгжүүлж аливаа өвчин эмгэгийг эрт илрүүлж, эмчлэх боломжийг бүрдүүлнэ.	<p>Хөхний төвд маммографийн аппаратыг хиймэл оюун ухаанд суурилсан програмтай холбож, хөхний хорт хавдрын оношилгоонд хиймэл оюун ухаанд суурилсан технологийг нэвтрүүлсэн байна.</p> <p>Умайн хүзүүний хорт хавдрын эрт оношилгоонд хиймэл оюун ухаанд суурилсан үтрээний дуран нэвтрүүлээ.</p> <p>2022 оноос АНУ–н Washington –ны Их Сургуулийн Эмнэлгийн хэрэгжүүлж буй “Туяа эмчилгээний салбарт хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх нь” төсөлд хамрагдан туяа эмчилгээний төлөвлөлтөд эрсдэл бүхий эрүүл эд эрхтнийг хиймэл оюун ухаан ашиглан дүрслэх туршилтын ажил хийгдэж байна.</p> <p>Туяа эмчилгээний төлөвлөлтийн Velocity программ нь хиймэл оюун ухааны функц ашиглан өвчтөний хийлгэсэн PET/CT болон MRI оношилгооны мэдээллийг туяа эмчилгээний төлөвлөлтийн системд Deformable байдлаар холбох чадвартай бөгөөд өвчтөний эмчилгээнд бай эзлэхүүнийг болон эрсдэл бүхий эрүүл эд эрхтэн дүрслэхэд хиймэл оюун ухааныг ашиглаж байна.</p>
30	2.2.39. Алслагдмал сум, орон нутаг, хот, нийслэлд амьдарч байгаа хүмүүст үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар ижил түвшинд очиж, цахим эрүүл мэндийн системд бүрэн шилжинэ.	<p>Телемедицины төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон хурлын тусгай өрөө байгуулсан. ЭМХТ-ийн телемедициний үндэсний сүлжээнд холбогдсон бөгөөд 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн Эрүүл мэндийн төвүүдтэй бүрэн холбогдсон. Зайн тусламж үйлчилгээний журмын дагуу зайн сургалт, эмч нарын зөвлөгөөнийг хийж байна.</p> <p>Сүхбаатар, Увс, Хөвсгөл, Баянхонгор, Баян-Өлгий аймагт 20 гаруй эмч ажиллаж, хөдөө орон нутгийн иргэдэд хавдрын тусламж үйлчилгээг газар дээр нь үзүүлсэн.</p> <p>ЭМС-ын А/367 тоот тушаалын дагуу Үндэсний багийн бүрэлдэхүүнд ХСҮТ-өөс Өвөрхангай, Хэнтий, Дорнод, Өмнөговь, Орхон аймгуудад 17 эмч хуваарийн дагуу томилогдон ажилласан.</p> <p>Тус ажлын хүрээнд Элэгний хавдрын оношилгоо, эмчилгээ болон хавдрын эсрэг системийн эмчилгээнүүдийг аймгуудад нутагшуулахаар ажиллаж байна.</p>

Тайлан хянасан: Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал
Нийгмийн эрүүл мэнд, төлөвлөлт сургалтын албаны дарга

Ц.Уранчимэг
Ц. Бадамсүрэн

Тайлан нэгтгэсэн: Хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн

А. Цэнд-Өлзий